

Байгаа зүйлдээ сэтгэл ханах нь аз жаргалын эх сурвалж

Цагаан давааны хогийн цэг. Хүн бүрийн нэрлэснээр хогийн төвлөрсөн цэг. Харин миний хувьд энэ бол хэний ч мэдэхгүй *бяцхан ертөнц бөгөөд оршихуй*.

Цагаан даваа руу чиглэх замд амаргүй дүр зураг угтав. Зам дагуу замбараагүй хог хаягдал, өгсүүр, бартаат хэсэг хогны машинууд дүрэмгүй мэт уралдан цуварна. Хогийн цэгийн үүдээр ормогц шил, төмөр зэрэг аюултай хаягдал хаа сайгүй. Машин техникт саад учруулах вий гэх айдастай байв. Ормогц хамар сэнхийтэл цоргих хурц үнэрээс зугтахыг хүснэ. Гэхдээ үнэрээс зугтахын оронд хормын зуур орчныг ажихад бүх зүйл өөрийн эрхгүй миний зүрхэнд өөрөөр өрнөсөн. Цагаан давааны хогийн цэгт ер бусын дүр зураг угтана. Хог хаягдлын дунд, жижиг том амбааруудыг эгнүүлэн байрлуулжээ. Эдгээр амбаар нь тэнд ажиллаж, амьдарч буй хүмүүсийн түр орон сууц гэхэд хилсдэхгүй. Хүйтний улиралд амбааруудын гадна гал түлж, орчныг дулаацуулж байгаа нь тодорхой. Зарим газраас ил гал асаж, түлэгдэж буй хог хаягдлын хар утаа суунаглана.

Хогийн цэгийн хамгийн баян айл

Тэр айл Приус 20 маркийн машинтай. Ийм газар амьдардаг хүмүүсийн хувьд ховор тохиох эд баялгийн илэрхийлэл. Хүмүүсийн дунд энэ машины эзэн хамгийн чинээлэг гэх яриа гарав.

Уг газарт хөл тавихаасаа өмнө би зөвхөн бохир тоос дарсан орчин, эвгүй үнэр, хэнд ч хэрэггүй болсон хаягдал зүйлсийн овоолго гэж боддог байлаа. Үнэндээ төсөөлснөөр бодит байдал үнэхээр л тийм байсан. Гэвч би энд ирээд энэ бодлоо өөрчлөхөөс өөр аргагүйд хүрсэн юм. Салхи исгэрч хог хаягдлын хөнгөн хэсгүүд энд тэндгүй таран хийсэж, шувуудын нислэгтэй ханьсан хэн нэгний хаясан гандсан хувцасны тасархай, үлдээсэн тоглоомын хэлтэрхийнүүд өөр нэгэн "амьдралын" эрэлд гарсан мэт харагдана.

Бидний мэддэггүй амьдралын өөр нэгэн өнгө. Хэрэггүй болсон хуванцар сав, хаягдсан хувцас, эвдэрхий тоглоом, тэр ч байтугай хоолны үлдэгдэл хүртэл хэн нэгний амьдралыг тэтгэдэг гэвэл та итгэх үү? Итгэх бүү хэл сонсоход ч магадгүй хэцүү байх.

Хогон дундаас товойн харагдах хөлдүү талбай, хуучирсан дугуйны хаймар, эвдэрхий тавилга дундаас хүн төрөлхтний өнгөрсөн амьдралын түүхийг ч магадгүй олж харж болохуйц. Гэтэл энэ хогон дунд хүмүүс амьдардаг. Тэнд хэн нэгний бяцхан зүрх ч цохилдог. Зарим нь хуванцар сав цуглуулж, төмөр эдлэл түүж, зүгээр л өөрийн амьдралын өдөр хоногийг аргацаан өнгөрүүлэх газар хайж ирсэн хүмүүс ч байв.

Хог асгах хэсэгт зөвхөн хогны машинууд бус, албан байгууллага, хувь хүмүүс ч хогоо асгадаг. Тэд хогны машины хаягдал дээр овоорохоос илүүтэй хувь хүмүүсийн хог руу тэмүүлж байгаа нь илт.

Тодруулбал хогийн цэгийн ажилчны хэлснээр хогны машинууд ихэвчлэн үнс болон дахин ашиглах боломжгүй зүйлс авчирдаг тул илүү үнэ хүрэхүйц зүйлсийг хайж олохыг зорьдог гэдгийг хуваалцсан юм. Учир нь тэдний амьдрал өдөр бүр амьд үлдэхийн төлөөх тэмцэл. Тэд хаягдлыг эрж, хэрэгтэй зүйлээ олж, оройн хоолоо залгуулдаг. Хоол хүнс, хувцас, заримдаа бүр инээд хөөрөө ч хогон дундаас олдог гэмээр.

Хаягдал биш, боломж бүтээсэн газар

“Монголын мэдээ”-нд онцлон нөхцөл байдал амаргүй байгаа талаар дурджээ. Улаанбаатар хотын хамгийн том хогийн цэгийн нэг болох Цагаан даваанд өдөрт дунджаар 1200-1300 тонн хог буудаг. Нийслэлийн нийт хог хаягдлын 60 хувийг бүрдүүлдэг гэхээр асар их хэмжээ. Гэвч хог хаягдлын дийлэнх нь ангилан ялгагдаагүй байдлаар шууд булшлагдаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Энэ асуудал нь бидний үлдээж буй ул мөр ч юм шиг. Хогийн цэг дээр амьдралаа залгуулдаг иргэдийн хувьд энэ орчин бол "бидний орхиод явдаг хог биш" харин амьдралынх нь эх үүсвэр. Эдгээр хүмүүс тогтмол орлогогүй, эрүүл мэндийн үйлчилгээ хязгаарлагдмал нөхцөлд аж төрдөг байна. Тэдний амьдралын нөхцөл байдлыг нарийвчлан судлах шаардлагатайг судлаачид онцолсон байдаг.

Бид өөрсдийн амьдралдаа "дутах юм алга" гэж боддог хэр нь хэн нэгнийг өөлж тааруу яваа нэгнээ улны хэмээн гоочилдог ч жинхэнэ улны амьдрал хаана байдаг гэдгийг үл мэднэ. Харин жинхэнэ улны амьдрал Цагаан давааны хогны төвлөрсөн цэг гэмээр. Гэхдээ би тэднийг улны гэж нэрлэхээс илүүтэйгээр жирийн нэгэн бидний төдийлөн мэддэггүй бяцхан ертөнц гэж харсан. Тэдний хувьд, нэг л шил, эвдэрхий тавилга, бүр урагдсан цамц ч

амьдралынх нь өнгийг өөрчилж баяр баясал нэмж чадна. Өнгө бүрдсэн энэхүү хачирхалтай ертөнцөд хүмүүс аз жаргалыг олж чадна гэдэг бэрх санагдах хэдий ч амьдрал бол зөвхөн бидний мэддэг хэв маяг биш. Амьдрал, үнэндээ, хогон дундаас цэцэглэж болох ажээ.

Хаягдсан тоглоом энд амьдардаг хүүхдүүдийн хувьд ирээдүйг харах, оюунаа тэлэх ганц боломж. Аз болж сургуульд орсон хүүхдүүдийн хувьд хогон дундаас үзэг хуучин форм дуусаагүй дэвтэр зэргийг олох нь тэнгэрийн одыг шүүрсэн мэт. Эвдэрхий тогоондоо хоол хийж, ойр хавьд олдсон бүхнээрээ аж төрөх тэдний амьдралын нэгээхэн хэсэг.

Хэн нэгний хаясан тоглоомоор хүүхдүүд сэтгэлээ баясгаж, олсон зузаан хувцас нь амьдралынх нь хүйтэн жаврыг зөөлрүүлж буй нь илхэн. Харин бид, илүү хангалуун, амьдралыг эдэлж үүнийг ойлгож, хүлээн зөвшөөрөх ёстой. Энэхүү нийтлэлийг уншиж чадаж байгаа нь ч өөрөө бидний боломжийн илэрхийлэл.

Гэсэн ч нийгмийн нэгээхэн хэсгийн хувьд хүртээмжгүй тансаглал. Бидний өдөр тутамд үнэлдэггүй зүйлс, жишээ нь уншиж бичих чадвар, тог цахилгаан, ухаалаг төхөөрөмж, гэх мэт нь зарим хүмүүсийн хувьд мөрөөдөл. Гэвч эдгээр боломжууддаа талархахын оронд илүү ихийг хүсэж, байхгүй зүйлсээ бид шаналал болгон хувиргадаг. Бидний хүсэл хязгааргүй брендийн цүнх, гоёмсог өсгийт, сүүлийн үеийн гар утас, төгс гадаад үзэмж. Энэ хязгааргүй хүсэл нь байгаа зүйлдээ сэтгэл ханах боломжийг хаадаг мэт.

Өнөөдрийг хүртэл олсон бүх зүйл бидний амьдралыг хангалттай сайн болгосон. Амьдралын үнэ цэнэ бол дутагдаж буйд биш, байгаа зүйлээ хэрхэн үнэлж, зөв зохистой ашиглаж буйд оршдог.

Талархал гэдэг зөвхөн сэтгэл ханамжийн эх булаг төдийгүй бидний амьдралыг зөв замд чиглүүлэх хүчтэй зэвсэг шиг. Бидэнд хаягдал мэт санагдах зүйлс тэдэнд ирээдүйн найдвар болж байгааг харахдаа өөрсдийн боломжуудыг илүү ихээр үнэлж, түүнээсээ аз жаргалыг мэдэрч сурах нь амьдралыг илүү утга учиртай болгох нь дамжиггүй биз ээ.

Алтан үзэгт зориулав ХИС сэтгүүл зүйн 3-р дамжааны оюутан Т.Наранзул

